

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН
ЧИГЛЭЛД ТУСГАГДСАН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН
ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/2017 оны эхний хагас жилийн байдлаар/

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын 2016 оны 70 дугаар тогтоолд тусгаснаар Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлогын хүрээнд Мал аж ахуй, газар тариалангийн салбарын үйлдвэрлэлийг дэмжиж, бүтээгдэхүүний гарц, ашиг шимийг нэмэгдүүлэх, Хүнс, хөнгөн, жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын хөгжлийг эрчимжүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилт бүхий 18 арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээний зорилго нь үндсэн чиглэлийн зорилт, үйл ажиллагааны гүйцэтгэлийг хүлээгдэж буй үр дүнд хүрч байгаа эсэхийг тогтоох, арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тодорхойлох, шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудад мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Хяналтад авсан арга хэмжээнүүдийн 2017 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов. Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтооход дээрх журмын “Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” тухай долоо дугаар бүлэгт заасныг баримталлаа. Уг тайлангийн хавсралтыг Засгийн газрын 89 дүгээр тогтоолоор баталсан журмын 4 дүгээр хавсралтын дагуу боловсруулав.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг тус яамны Төрийн захиргааны удирдлагын газрын нэгтгэн ирүүлсэн “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн тайланг нягтлан үзэх, зарим арга хэмжээний хэрэгжилтийг хариуцсан албан тушаалтнуудтай уулзаж тодруулах замаар цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн гүйцэтгэв. Төлөвлөсөн арга хэмжээ бүрээс хэрэгжүүлэх хугацааны төгсгөлд гарах дүнг урьдчилсан байдлаар тогтоож, үнэлгээ хийх үед гарсан бодит үр дүнгийн түвшинтэй харьцуулж хувиар илэрхийлэн үнэлгээг тодорхойлов.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний товчоо (арга хэмжээгээр)

Хүснэгт 1

Бодлого	Зорилт	Арга хэмжээ	Арга хэмжээний биелэлт, хувиар					Дундаж үнэлгээ, %
			100 ¹	70 ²	40 ³	0 ⁴	(-) ⁵	
- Мал аж ахуй, газар тариалангийн салбарын үйлдвэрлэлийг дэмжиж, бүтээгдэхүүний гарц, ашиг шимийг нэмэгдүүлэх	2	18	-	2	15	1	-	41.1

¹ “үр дүнтэй” – зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага, зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол 100 хувь /90-100 хүртэл хувь/;

² “тодорхой үр дүнд хүрсэн” - зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70 хувь /60-89 хүртэл хувь/;

³ “эрчимжүүлэх шаардлагатай” - зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай бол 40 хувь /31-59 хүртэл хувь/;

⁴ “үр дүнгүй” – зорилго, зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв, хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага, зохион байгуулалт хангалтгүй бол 0 хувь /0-30 хүртэл хувь/;

⁵ “үнэлэх боломжгүй” – зорилго нь тодорхойгүй, шалгуур үзүүлэлт нь шаардлага хангаагүй, эсхүл шалгуур үзүүлэлттэй боловч гүйцэтгэлийг үнэлэхэд хангалттай мэдээлэл байхгүй, төсөв хөрөнгө тодорхойгүй, гадаад хүчин зүйлсээс шалтгаалсан зэргийг баримтлан нотолсон бол.

- Хүнс, хөнгөн, жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын хөгжлийг эрчимжүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх										
---	--	--	--	--	--	--	--	--	--	--

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах арга хэмжээний гүйцэтгэл 2017 оны эхний хагас жилийн байдлаар 41.1 хувьтай үнэлэгдэв. Үүнд, 2 арга хэмжээ **“тодорхой үр дүнд хүрсэн”**, 15 нь **“эрчимжүүлэх шаардлагатай”** гэсэн бол Бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн менежментийг сайжруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлыг **“үр дүнгүй”** гэж үнэлсэн байна. **“Үр дүнтэй”** ба **“үнэлэх боломжгүй”** үйл ажиллагаа байхгүй.

2. Үндсэн чиглэлийн санхүүжилт

Хүснэгт 2

	Улсын төсөв		Гадаад эх үүсвэр		Хувийн хөрөнгө оруулалт		Бусад эх үүсвэр		Дүн		
	Төлөв.	Гүйцэт.	Төлөв	Гүйцэт.	Төлөв	Гүйцэт.	Төлөв	Гүйцэт.	Төлөвлөсөн нийт дүн	Зарцуул. хөрөнгийн дүн	Санхүүжилтын зөрүү
Санхүүжилт, тэрбум төгрөг	84.6	31.9	14.0	-	15.0	-	1.3	-	114.8	31.9	82.9

2017 оны үндсэн чиглэлд улсын төсвийн хөрөнгөөс 84.56 тэрбум, гадаадын эх үүсвэрээс 14.0 тэрбум, хувийн хөрөнгө оруулалтаар 15.0 тэрбум, бусад эх үүсвэрээс 1.3 тэрбум, нийт 114.86 тэрбум төгрөгний санхүүжилт тус тус авахаар төлөвлөснөөс эхний хагас жилийн байдлаар зөвхөн улсын төсвөөс 31.93 тэрбум төгрөг зарцуулаад байна. Энэ нь төлөвлөсөн нийт дүнгийн 27.8 хувь, улсын төсвийн хөрөнгө оруулалтын 37.8 хувь болж байна. Хугацааны туршид гадаад, бусад эх үүсвэрээс болон хувийн хөрөнгө оруулалтаас санхүүжилт хийгдээгүй байна.

3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний товчоо (салбараар)

Хүснэгт 3

	2017 он	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАР				
		МААБХЗГ/ МЭҮГ/ УСҮТ/ АДОБАЗ/ БТГ	ГТБХЗГ	ХөҮБХЗГ /БТГ	ЖДҮХБХЗГ/ ЖДҮХС	ХҮҮБХЗГ /БТГ
Нийт	18	6	3	4	1	3
Үүнээс	“үр дүнтэй”	-	-	-	-	-
	Бүгд	18	6	3	4	3
	тодорхой үр дүнд хүрсэн (70%)	2	1	1	1	-
	эрчимжүүлэх шаардлагатай (40%)	15	4	2	3	3
	үр дүнгүй (0%)	1	1	-	-	-
“үнэлэх боломжгүй”	-	-	-	-	-	
Үнэлгээ	41.3	38.3	50.0	47.5	40.0	40.0

Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг салбар бүрээр авч үзвэл Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 6 арга хэмжээг 38.3 хувийн, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 3 арга хэмжээг 50.0 хувийн, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар

4 арга хэмжээг 47.5 хувийн, Жижиг дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 1 арга хэмжээг 40.0 хувийн, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 3 арга хэмжээг 40.0 хувийн гүйцэтгэлтэйгээр тус тус хэрэгжүүлсэн байна. Бодлого, төлөвлөлтийн газар үндсэн чиглэлийн үйл ажиллагааг ГТБХЗГ-аас бусад газартай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн тул тусгайлан үнэлэгдээгүй болно.

Дөрөв. Дүгнэлт

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах арга хэмжээний гүйцэтгэл 2017 оны эхний хагас жилийн байдлаар 41.1 хувьтай үнэлэгдэв.

2. Үндсэн чиглэлд улсын төсвийн хөрөнгөөс 84.56 тэрбум, гадаадын эх үүсвэрээс 14.0 тэрбум, хувийн хөрөнгө оруулалтаар 15.0 тэрбум, бусад эх үүсвэрээс 1.3 тэрбум, нийт 114.86 тэрбум төгрөгний санхүүжилт тус тус авахаар төлөвлөснөөс эхний хагас жилийн байдлаар зөвхөн улсын төсвөөс 31.93 тэрбум төгрөг зарцуулаад байна.

3. МААБХЗГ 6 арга хэмжээг 38.3 хувийн, ГТБХЗГ 3 арга хэмжээг 50.0 хувийн, ХөҮБХЗГ 4 арга хэмжээг 47.5 хувийн, ЖДҮХБХЗГ 1 арга хэмжээг 40.0 хувийн, ХүҮБХЗГ 3 арга хэмжээг 40.0 хувийн гүйцэтгэлтэйгээр тус тус хэрэгжүүлсэн байна.

Тав. Зөвлөмж

1. ХХААХҮЯ-ны Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн нийт 18 арга хэмжээний 15 нь 40 хувь буюу зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай хэмээн дүгнэгдсэн тул бүх газар, харьяа байгууллага хэрэгжилтийг хангаж ажиллах.

2. Үр дүнгүй хэмээн үнэлэгдсэн “Бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн менежментийг сайжруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх ажил” нь төлөвлөлт бодитой бус, бэлтгэл ажил хангагдаагүй үлдсэн хагас жилийн хугацаанд тавьсан зорилтот түвшинд хүргэж, шалгуур үзүүлэлтийг хангахын тулд үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай.

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(2017 оны эхний хагас жилийн байдлаар)

Д/д	Дунд хугацааны бодлогын баримт бичиг	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2017 онд хүрэх зорилтот түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр		Хүрсэн түвшин, хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
					Төлөв /тэрбум төгрөг/	Гүйцсэн /тэрбум төгрөг/		
1	2	3	4	5	6	7	8	10
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО								
Зорилт 3. Мал аж ахуй, газар тариалангийн салбарын үйлдвэрлэлийг дэмжиж, бүтээгдэхүүний гарц, ашиг шимийг нэмэгдүүлнэ								
3.1	МУТХҮБ-ын 2.1.1, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.33 дахь заалт	Малын ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор малын удмын санг хамгаалж, үржил селекцийн аргаар шинэ үүлдэр, омгийг бий болгох	Импортоор авах болон дотоодод үйлдвэрлэх үхрийн гүн хөлдөөсөн үр, мян.тун	100	0.22 Улсын төсөв	0,004	<p>- Төв, Хэнтий, Баянхонгор, Ховд, Говь-Сүмбэр 5 аймагт үржүүлж буй удмын сан нь алдагдахад хүрсэн Өнжүүл, Алтанбулаг, Тал нутгийн цагаан, Байдраг, Торгууд, Сүмбэр зэрэг үүлдрийн шилмэл хээлтүүлэгчээс 2017 онд үр үйлдвэрлэж, генийн санд хадгалах ажлын бэлтгэлийг хангах хүрээнд дээрхи аймгуудаас үр үйлдвэрлэлд ашиглах хээлтүүлэгчийг сонгох чиглэлээр албан тоот хүргүүлэн, судалгаа гаргаж байна. Нийт 327 толгой хээлтүүлэгчээс цэвэр үүлдрийн 197, эрлийз 129, стандартын шаардлага хангасан 162 толгой хээлтүүлэгч байгаа бөгөөд хаврын үзлэг, ангилалтаар дахин шилэн сонголт хийх юм.</p> <p>- 2017 онд 21 аймаг, нийслэлийн 142 сум, дүүргийн бод /үхрийн/ малын 6092 толгой хээлтэгч, бог малын 14160 толгой хээлтэгч малд зохиомол хээлтүүлэг хийх захиалга авч, орон нутагт үйлчилгээ хийж байгаа бөгөөд 2017 оны эхний хагас жилийн байдлаар 15 мал үржүүлгийн техникч орон нутагт ажиллаж, 835 толгой үнээг зохиомлоор хээлтүүлээд байна. Үржлийн ажлын чанарыг сайжруулах жилийн хүрээнд 2017 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн “Зохиомол хээлтүүлгийн үйлчилгээг өргөжүүлэх аян”-ыг зарлан энэ ажлын хүрээнд 21 аймаг нийслэлээс авсан захиалгын дагуу 6000 толгой үнээ хээлтүүлэхээр 22 мал үржүүлгийн техникчийг орон нутагт томилон ажиллуулахаар шаардагдах өндөр ашиг шимт бухны гүн хөлдөөсөн үр, азот, багаж хэрэгслэлээр хангаж зохиомол хээлтүүлгийн ач тус, давуу талыг сурталчилан таниулах ажлыг зохион байгуулж байна.</p> <p>- 2017 оны үр үйлдвэрлэлийн ажлын хүрээнд Малын удмын сангийн үндэсний төвөөс “Газар-Агро” ХХК-тай хамтран ажиллах гэрээг байгуулан, тус төвийн мэргэжлийн баг Сэлэнгэ</p>	70

							аймгийн Зүүнбүрэн суманд үйл ажиллагаа явуулж буй “Шим бүрэн” ХХК-ийн ОХУ-аас импортлон цэврээр үржүүлж байгаа махны чиглэлийн Герефорд үүлдрийн 10 бухнаас үр үйлдвэрлэх ажлыг явуулын лабораториор технологийн түвшинд гүйцэтгэн 12,0 мянган тун чанарын шаардлага хангасан үрийг үйлдвэрлэлээ. Энэ үйл ажиллагаанд 4.0 сая төгрөг зарцуулсан. Эдгээр үрийг Монголын махны үхрийг үржүүлэх бүс нутаг болон Сэлэнгэ аймгийн Орхонтуул, Хушаат сум, Булган аймгийн Сэлэнгэ суманд үржүүлж буй Сэлэнгэ, Казакын цагаан толгойт үүлдрийн үхрийн үржлийн чанарыг сайжруулахад зохиомол хээлтүүлэгт ашиглах юм. Герафорд үүлдэрийн махны чиглэлийн үхрээс 30,0 мян.тун гүн хөлдөөсөн үр дотоодод үйлдвэрлэн нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 200,0 сая төгрөгийн тендерийг зарлаад байна.	
3.2	МУТХҮБ-ын 2.1.1, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.32 дахь заалт	Малын гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлэх	Хамрагдах малын тоо, сая толгой	44-өөс доошгүй	21.9 Улсын төсөв	5.3	Орон нутгийн захиалгын дагуу малын 19 нэрийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2017 оны 06-р сарын 05-ны байдлаар тэмцэх арга хэмжээний хүрээнд 2017 он гарсаар 17,1 сая толгой малыг хамруулаад байна. Мал амьтны гоц халдварт шүлхий өвчний вакцинжуулалтанд 4,4 сая толгой, хонины цэцэг өвчний дархлаажуулалтанд 7,3 сая бог малын мялзангаас сэргийлэх вакцинжуулалтад 0,34 сая толгой мал тус тус хамрагдаад байна. Энэ оны 06-р сарын 05-ны байдлаар улсын хэмжээнд халдварт, гоц халдварт өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтанд давхардсан тоогоор нийт 29,1 сая толгой мал хамрагджээ. МЭУСАХ-ний халдварт болон гоц халдварт өвчний эхний хагас жилийн байлаар санхүүжигдэх хуваарийн дагуу 10.4 тэрбум төгрөг батлагдсанаас 5.3 тэрбум төгрөг зарцуулагдаад байна. Үүнээс биобэлдмэлийн үнэд 2.4 тэрбум, гоц халдварт шүлхий цэцэг өвчний үйлчилгээний хөлс болон бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээнд 2.5 тэрбум төгрөг, лабораторийн оношлогоо шийнжилгээнд 151.5 сая төгрөг, тандалт шинжилгээний зардалд 46 сая төгрөг тус тус зарцуулагдаад байна.	40
3.3	МУТХҮБ-ын 2.1.1, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.36 дахь заалт	Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор отрын бүс нутаг, нөөц бэлчээрийг нэмэгдүүлж, бэлчээрт хөнөөл учруулдаг мэрэгч амьтан, шавьжтай тэмцэх	Нөөцөд авах нийт бэлчээрийн талбайн хэмжээ, мян.га	750	1.8 Улсын төсөв	-	-Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бэлчээр шинээр бий болгох судалгааны ажлын үр дүнд Хөвсгөл аймгийн Арбулаг сумын 45 мян.га, Бүрэнтогтох сумын 17.1 мян.га, Тосонцэнгэл сумын 1.0 мян.га, Цагаан-Уул сумын 17.2 мян.га, Төмөрбулаг сумын 7.6 мян.га, Цэцэрлэг сумын 87.0 мян.га нутгуудыг отрын бэлчээрээр ашиглах боломжтой болохыг тогтоосон. Үүнээс: Төмөрбулаг сумын 7.6 мян.га, Цэцэрлэг сумын 87.0 мян.га бэлчээрийг аймаг дундын отрын	40
			Үлийн цагаан оготной тэмцэх талбайн хэмжээ, мян.га	650		0.2	40	

			Царцаатай тэмцэх талбайн хэмжээ, мян.га	100		0.36	<p>бэлчээр болгох тохиромжтой гэж үзэн, тус газруудыг аймаг дундын отрын нөөц нутаг болгох талаар орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад холбогдох саналыг хүргүүлэн, шийдвэр гаргуулахаар ажиллаж байна. /Одоо байгаа отрын бүс нутаг-783,3 мян.га/</p> <p>2017 онд улсын төсвийн хөрөнгөөр 12 аймаг, аймаг дундын отрын бэлчээр нийт 580.0 мян га-д үлийн цагаан оготнотой микробиологийн болон энгийн механик аргаар тэмцэнэ. Үүнээс: Баянхонгор, Өвөрхангай аймгийн 100.0 мянган га бэлчээрт микробиологийн аргаар үлийн цагаан оготнотой тэмцэхэд зориулж 200.0 тн бактерийн бэлдмэл худалдан авч, ажил, үйлчилгээний хөлсийн хамт 400.0 сая төгрөг зарцуулна. 10 аймаг, аймаг дундын отрын бүс нутагт 480 мян га бэлчээрт 768.0 сая төгрөгөөр энгийн механик аргаар үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг зохион байгуулна.</p> <p>2 дугаар улирлын байдлаар Баянхонгор, Өвөрхангай аймгийн 50.0 мянган га бэлчээрт микробиологийн аргаар үлийн цагаан оготнотой тэмцэхэд зориулж 100.0 тн бактерийн бэлдмэл худалдан авч, ажил, үйлчилгээний хөлсийн хамт 200.0 сая төгрөгийн АГТ 170407/04-052 дугаар гэрээг “Шим” ХХК-тай байгуулж ажлын гүйцэтгэлд хяналт тавин хүлээн авлаа.</p> <p>2017 онд Ховд, Баян-Өлгий, Говь-Алтай аймагт 89.8 мян.га-д царцаатай тэмцэх бэлтгэл ажлын хүрээнд 119.0 мянган төгрөгөөр царцаатай тэмцэх 13500 литр Карате бодисыг худалдан авч Баян-Өлгий аймагт 6.0 мянган литр, Ховд аймагт 6.0 мянган литр, Говь-Алтай аймагт 1.5 мянган литрийг хуваарилан хүргүүлж 6 дугаар сард хийх ажлыг гүйцэтгэж байна. Ажил, үйлчилгээний хөлсөнд 360.0 сая төгрөг зарцуулна. Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн А-131 дугаар тушаалаар Үлийн цагаан огтоно, царцааны тархалтын хөнөөлийн тодотгох судалгааг Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнтэй 170503/04-069 дугаар гэрээг байгуулан гүйцэтгүүлж байна. Ажлын санхүүжилт нь 17.0 сая төгрөг, огтоно, царцаатай тэмцэх ажлын үйл явцад хяналт тавих томилолтын зардалд 3.5 сая төгрөг төлөвлөсөн бөгөөд бэлчээрт хөнөөл учруулдаг мэрэгч амьтан, шавьжтай тэмцэх арга хэмжээний зардал нийтдээ 1.7 тэрбум төгрөг болно.</p>	40
3.4	МУТХҮБ-ын 2.1.1, Зорилт 3, ЗГҮАХ-	Газар тариалангийн салбарт лизингийн үйлчилгээг хөгжүүлж, техник, тоног	Техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлийн	70.0	14.0 Гадаад эх үүсвэр	18.6 сая доллар Хүлээгдэж	Газар тариалангийн техникийн шинэчлэл төслийн танилцуулга, лизинг, санхүүжилтийн схемийг боловсруулан төслийг хэрэгжүүлэх саналыг Монгол Улсын Хөгжлийн банк, Сангийн яаманд албан бичгээр тус тус хүргүүлсэн. Орос улсад	40

	ийн 2.45 дахь заалт	төхөөрөмжийн шинэчлэл хийх	хувь			байгаа Улсын төсөв 0.95	<p>үйлдвэрлэсэн хөдөө аж ахуйн зориулалттай техникийг худалдан авахад зориулж ОХУ-ын Хөгжлийн банкнаас 11,0 сая ам. долларын хөнгөлөлттэй зээлийг Монгол Улсын Хөгжлийн банкаар дамжуулан авч хөдөө аж ахуйн зориулалттай техник, тоног төхөөрөмж худалдан авах “Тазар тариалангийн техникийн шинэчлэл” төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Тус төслийн талаар Монгол Улсын Засгийн газрын 2017.05.24-ний өдрийн 23 дугаар хуралдаанд танилцуулсан. Төслийг хэрэгжүүлснээр жилд 48.0 мянган га талбайн уринш боловсруулах, 15.6 мянган га талбайд үр тариа тариалж 27.3 мянган га талбайн үр тариаг технологийн хугацаанд хураан авах техникийн боломж бүрдэнэ. Жилд 54.6 мянган тонн үр тариа, 50.4 мянган тонн ногоон тэжээл хураан авах боломж бүрднэ.</p> <p>БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн 7.6 сая ам. долларын хөрөнгөөр Хөдөө аж ахуйн зориулалттай дунд оврын 140 ширхэг трактор, нийт 8 төрлийн 260 ширхэг хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийг худалдан авч аж ахуйн нэгж, хоршоонд хөнгөлөлттэй зээл, лизингээр олгохоор төлөвлөж байна. Энэхүү төслийг хэрэгжүүлснээр газар тариалангийн зүтгэх хүчний техникийн хүчин чадал одоо байгаа түвшинөөс 10%-иар нэмэгднэ. Улсын төсвийн тодотголд 1.9 тэрбум төгрөг тусган дунд оврын трактор, хүнсний ногооны 27 иж бүрдэл техникийг нийлүүлэхээр тендер зарласан. Худалдан авсан трактор, техник, тоног төхөөрөмжийг техникээр төлбөртэй үйлчилгээ үзүүлэх ногоочид, ногоочдын хоршоонд хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох ба ингэснээр нийт 600 га талбайн хүнсний ногооны хөрс боловсруулах, арчлах, хураах ажлыг механикжуулна. Дээрх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр газар тариалангийн техникийн шинэчлэл 72.0 хувьд хүрнэ.</p>	
3.5	МУТХУБ-ын 2.1.1, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.41 дэх заалт	Таримал ургамлын үрийн аж ахуйг хөгжүүлж, нутагшсан сортын үрийн нөөц бүрдүүлэх замаар үрийн сорт, чанарыг сайжруулах	Үрийн нөөц бүрдүүлэх аж ахуйн тоо	3	1.6 Улсын төсөв	1.505	<p>Үр тариа, тэжээлийн таримлын анхдагч үрийн аж ахуйг дэмжих, хүчин чадлыг нь сайжруулах элит үр үржүүлж нөөц бүрдүүлэх, үрийн шинэчлэлийг эрчимжүүлэх асуудлыг шийдвэрлэхээр “Үрийн аж ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай” ХХААХҮ-ийн сайдын 2017 оны 03.03-ны өдрийн А/31 дугаар тушаалаар хэрэгжилтийг зохион байгуулж байна. Улсын төсвийн 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгөөр Ургамал газар тариалангийн хүрээлэнг түшиглэн Дархан-Уул аймгийн Хонгор, Өвөрхангай аймгийн Хархорин суманд анхдагч үрийн аж ахуй байгуулахаар төлөвлөж байна. Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлснээр улаанбуудайн 2500 тн,</p>	40

							тэжээлийн болон сэлгээний таримлын 800 тн элит үр үйлдвэрлэж дотоодын хэрэгцээгээ хангадаг болно Төмсний үр шинэчлэлд зориулан вирусгүй бичил булцууг үржүүлэн 35,2 тонн элит үр үйлдвэрлэснийг аймгуудын Хөдөө аж ахуйн газраар дамжуулан хуваарилав. Тариалангийн төв бүсээс үр тариа, тэжээлийн таримлын үр үржүүлэх 11 аж ахуйн нэгжийг сонгон шалгарууж Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А-157 дугаар тушаалаар үр үржүүлэх тусгай зөвшөөрөл олгож ТЭДС болон УГТХ-тэй хамтран ажиллах гэрээ байгуулсан. 2017 онд Улсын төсвийн 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгөөр анхдагч үрийн аж ахуйд техникийн шинэчлэл хийх зорилгоор трактор, үр тариа хураах комбайн, үрлүүр, сийрүүлүүр, хор шүршигч, үр сортлогч тус бүр 2 ширхэгийг худалдан авах ажлыг зохион байгуулж байна.	
3.6	МУТХҮБ-ын 2.1.1, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 2.44 дэх заалт	Өвөл, зуны хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж, хот суурин газрын хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор хангах	Шинээр нэмэгдэх хүлэмжийн талбайн хэмжээ, мян.м2	100	15.0 Хувийн хөрөнгө оруулалт	Улсын төсөв 0.95	Монгол улсын Засгийн газрын “Эдийн засгийг сэргээх” хөтөлбөрийн төлөвлөгөөнд 5 га (50.0 мян.м2) талбай бүхий өвлийн хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулахаар тусгуулж, хүлэмжийн аж ахуй байгуулах төслийг боловсруулж Хөгжлийн банк, Үндэсний хөгжлийн газарт хүргүүлэв. Олон улсын банк, санхүүгийн байгууллагын санхүүжилтээр өвлийн болон зуны нийлэг хальсан хүлэмжийн хангамжийг нэмэгдүүлэх санал боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлээд байна. Улсын төсвийн тодотголд 1.9 тэрбум төгрөг тусган 800 иж бүрдэл 78,0 мянган га талбай бүхий нийлэг хальсан хүлэмж нийлүүлэхээр тендер шалгаруулалт зарласан. Үүний үр дүнд таримлын нэр төрөл нэмэгдэн, үйлдвэрлэл 1000.0 тонноор нэмэгдэнэ.	40
			Хүлэмжийн ургацын нэмэгдэх хэмжээ, мян.тонн	4			40	
3.7	МУТХҮБ-ын 2.1.1, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.36 дахь заалт, ЗГҮАХ-ийн 2.37 дахь заалт	Бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн менежментийг сайжруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-		Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай Улсын Их хурлын 2017 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 11 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа”-наас отрын бэлчээрийг ашиглах, хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулж байна. Энэхүү хууль батлагдсанаар аймаг дундын отрын бэлчээрийн асуудал эрхэлсэн төрийн болон бэлчээр ашиглагчийн эрх, үүрэг, хариуцлага тодорхой болж, бэлчээрийн ашиглалт, хамгаалалт сайжирч Монголын нүүдлийн соёл иргэншлийг хадгалах, хойч үеийнхэнд өвлүүлэн үлдээх, бэлчээрийг урт хугацаанд тогтвортой ашиглах нөхцөл бүрдэнэ.	0

3.8	МУТХҮБ-ын 2.1.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.18 дахь заалт	“Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх, хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, стратегийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах зорилгоор “Мах, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулж, хүн амыг эрүүл, аюулгүй бүтээгдэхүүнээр хангах	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	30.0	-	0,05	<p>“Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” зорилтын дор үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Төслийг боловсруулах нөхцөл байдлын дүн шинжилгээ, суурь судалгааг хийж байна.</p> <p>Мах, сүүний анхдугаар аяныг зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн А-45 дугаар тушаалаар батлуулсан. Төлөвлөгөөний дагуу 2017-2020 онд 5 зорилтын хүрээнд нийт 50 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Аяны хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулаад байна.</p> <p>1.Мах, сүүний анхдугаар аяны хүрээнд орон нутгийн сүүний нөөцөд тулгуурлан байгуулах хуурай сүүний бага, дунд оврын үйлдвэрийн тоног төхөөрөмжийг танилцуулах практик сургалт, хэлэлцүүлгийг “MDM” ХХК-тай хамтран 2017 оны 2 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулсан. Сургалтад Говь-Алтай, Баянхонгор, Архангай, Өвөрхангай, Булган, Сэлэнгэ, Хэнтий, Дорнод аймгаас болон Улаанбаатар хотоос сүү үйлдвэрлэгчид, фермерүүд, хоршоологчид, сүүний салбарын мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөл нийт 100 гаруй хүн оролцсон. “MDM” ХХК-ийн боловсруулсан “Монгол хуурай сүү” төслийг дэмжиж, санхүүжилтын эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр Хөгжлийн банкинд 2017 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 01/730 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Тус төслийн хүрээнд эхний ээлжийн тоног төхөөрөмжүүд 2017 оны 6 сард багтан орж ирэх тооцоотой байна.</p> <p>2.Монголын сүүний салбарыг хөгжүүлэх үндэсний зөвлөл, НҮБ-ын ХХААБ-ын төлөөлөгчийн газар, “Глобал коммунитис” олон улсын байгууллагатай хамтран “Монгол Улсын сүүний салбарын тогтвортой хөгжлийн чиглэл” уулзалт, хэлэлцүүлгийг 2017 оны 3 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулав. Хэлэлцүүлгээр Мах, сүүний анхдугаар аяны хүрээнд дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ болон Азийн сүүний үйлдвэрлэлийн зөвлөлдөх уулзалтаас 2015 онд гаргасан стратегиудын талаар хэлэлцэж, санал, мэдээлэл солилцсон.</p> <p>3.Гаалийн албан татвараас чөлөөлөх жижиг, дунд үйлдвэрийн тоног төхөөрөмжийн жагсаалтыг боловсруулж Засгийн газрын 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулав. Энэ жагсаалтад мах, сүү боловсруулах үйлдвэрүүдэд шаардагдах тоног төхөөрөмжүүдийг багтаасан.</p> <p>4.Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн хурлаар</p>	40
-----	--	--	-------------------------------	------	---	------	--	----

						<p>стратегийн хүнсний экспорт, импортын тоо хэмжээний квот тогтоох асуудлыг 2017 оны 1 дүгээр сард хэлэлцүүлсэн. Хурлаар 2017 онд хонь, ямааны махны экспортод квот тогтоохгүй, мөн шингэн сүү импортлохгүй байхаар шийдвэрлэж зөвлөмж гаргасан. Энэ нь мах, сүү боловсруулах дотоодын үйлдвэрлэлийг дэмжсэн арга хэмжээ болж байна.-100</p> <p>5.Монголын “Эко мийтфүүд” ХХК-иас ИБНИУ /Исламын бүгд найрамдах Иран улс/-д 4 мянган тн хонины мах экспортлох гэрээг байгуулсан. Тус компани 2017 оны 6 дугаар сарын 25-нд эхний ээлжийн 100 тн махыг гаргахаар бэлтгэл ажлаа хангаж байна.</p> <p>6.Туркийн олон улсын хамтын ажиллагааны агентлагтай хамтран тус агентлагийн санхүүжилтээр “Мал нядалгааны халал стандартыг нэвтрүүлэх нь” сургалтыг 2016 оны 12 дугаар сард зохион байгуулсан. Сургалтад хамрагдсан мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрлэлийн салбарын нийт 60 хүнд сертификат олгож, салбарын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлсэн. Мөн тус байгууллагын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Говь-Алтай аймгийн Чандмань суманд мал төхөөрөх, мах боловсруулах жишиг үйлдвэр байгуулахаар шийдвэрлэсэн.</p> <p>7.Мал амьтны эрүүл мэндийн тухай, Малын генетик нөөцийн тухай хуулийн төслүүдийг УИХ-д хэлэлцүүлж байна. /УИХ-ын 2017 оны хаврын чуулганаар батлагдана гэсэн хүлээлтэй/ Хууль батлагдсанаар Мах, сүүний анхдугаар аян хэрэгжих нөхцөл бүрдэнэ.</p> <p>8.Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийн болон Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулаад байна.</p> <p>9.Дулааны аргаар мах боловсруулах 8 үйлдвэрийн өргөтгөл, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, мөн орон нутаг дахь сүүний нөөцийг эргэлтэд оруулж ээдэмцэр үйлдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээний санал боловсруулж, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулахаар Үндэсний хөгжлийн газарт холбогдох материалын хамт хүргүүлсэн.</p> <p>10.Орон нутагт ашиглагдахгүй байгаа сүүний нөөцийг ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор Монголын ээдэмцрийн холбооноос боловсруулж ирүүлсэн “Ээдэмцэр” кластер төслийг дэмжиж Хөгжлийн банкинд 2017 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн 01/1306 дугаар албан бичиг хүргүүлсэн.</p> <p>11.Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа</p>
--	--	--	--	--	--	--

						<p>“Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд сүүний салбарт хийгдэх ажлын төлөвлөгөө, төсвийг боловсруулж төслийн удирдах нэгжид хүргүүлсэн. Төслийн хүрээнд сүүний боловсруулах болон сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуйг дэмжих зорилгот арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.</p> <p>12.Монгол Улс, БНПУ-ийн Засгийн газар хоорондын хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэх Баянхонгор, Өвөрхангай аймгийн Хангайн бүсийн сумдын малчдыг түшиглэн сарлагийн сүү бэлтгэл-үйлдвэрлэлийн эдийн засгийн үр ашигтай бренд гаргах, үйлдвэр байгуулах төслийн баримт бичгийг боловсруулж Сангийн яаманд хүргүүлсэн-30</p> <p>13.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт 2017 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний ерөнхий төлөвлөгөөний дагуу сүүний үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний, мөн сүүний тоног төхөөрөмж, мал нядлах явуулын үйлдвэрийн тоног төхөөрөмж худалдан авах тендерийн баримт бичгүүдийг боловсруулж байна.</p> <p>14.“Дэлхийн сүүний өдөр” арга хэмжээг “Эх орны сүү – Эрүүл хүнс” уриан дор 2017 оны 6 дугаар сарын 01-10-нд НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын суурин төлөөлөгчийн газар, Монголын сүүний нэгдсэн холбоо, Сүүний салбарыг хөгжүүлэх үндэсний зөвлөлтэй хамтран зохион байгуулав. Сүхбаатарын талбайд 6 дугаар сарын 09-10-нд зохион байгуулсан өдөрлөгийн арга хэмжээнд сүү боловсруулах салбарын 10 гаруй аж ахуйн нэгж оролцож, сүү хэрэглэх ач холбогдол, сүүний хэрэглээг нэмэгдүүлэх талаар сурталчилгааны ажлууд зохион байгуулав.</p> <p>15.Мах, сүүний анхдугаар аяны хүрээнд "Мал, мах бэлтгэлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2017 оны 14 дүгээр тогтоолын дагуу мах боловсруулах үйлдвэр, мах хадгалах зориулалтын зоорь бүхий аж ахуй нэгжүүд өвөлжилт хүндэрсэн орон нутгаас мал, мах бэлтгэж, 2017 оны 4-7 дугаар сард Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын хэрэгцээнд худалдан борлуулж байна. 2017 оны 4 дүгээр сарын 10-наас 6 дугаар сарын 13-ны өдрийг хүртэл нийт 11.26 мянтрн мах буюу арга хэмжээний хүрээнд бэлтгэсэн махны 71 хувийг худалдан борлуулаад байна. /үүнээс: хонины мах 4.74, ямааны мах 3.35, үхрийн мах 3.17 мян.тн/</p> <p>16.Малын тэжээлийн ургамал тариалах гэж буй иргэн, аж ахуйн нэгжид 30 хувийн урьдчилгаа төлөх, үлдэх төлбөрийг</p>
--	--	--	--	--	--	---

						<p>хураалтын дараа олгох нөхцөлтэйгээр ТЭДС-гаас шатахуун, мөн арвай, хөх тариа, вандуй, овъёос зэрэг таримлын нийт 180.9 тн үрийг олгох ажлыг зохион байгуулсан. Мөн улаанбуудай тариалдаг аж ауйн нэгжүүдээс гаргасан малын тэжээл тариалах хүсэлтүүдийг нэгтгэн ТЭДС-д хүргүүлсэн.-70</p> <p>17.Тэжээлийн үйлдвэрийн судалгааг орон нутгаас авч нэгтгэн, байршлын судалгаа гаргаж, шинээр 3 бүсэд тэжээлийн үйлдвэр байгуулах үндэслэл, тооцоог хийгээд байна.</p> <p>18.Хүн ам төвлөрсөн хот, суурин газрын сүүний хэрэгцээг хангах, сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуйг дэмжих зорилгоор Мал хамгаалах санд төвлөрсөн хөрөнгө /800.0 сая/-өөс сүү-махны чиглэлийн үхрийн аж ахуй эрхлэгч жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд чиглэсэн хөнгөлөлттэй зээлийг олгох төсөл сонгон шалгаруулалтыг зарлаад байна. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалт /2.5 тэрбум/-аар сүү-махны чиглэлийн арвин ашиг шимтэй цэвэр үүлдрийн үхэр импортлох, нутагшуулах ажлыг зохион байгуулахаар бэлтгэж байна.</p> <p>19.Улсын төсвийн хөрөнгө оруулалт /200 сая/-аар махны чиглэлийн “Терфорд” үүлдрийн үхрийн гүн хөлдөөсөн үрийг дотооддоо үйлдвэрлэх төсөл сонгон шалгаруулалт зарлахаар бэлтгэл ажлыг хангаж байна.</p> <p>20.Мах, сүүний чиглэлийн өндөр ашиг шимтэй, импортоор орж ирсэн цэвэр үүлдрийн үхрийн үр төл, хээлтүүлэгчийг авч энэ төрлийн аж ахуй эрхлэгч, жижиг, дунд фермерүүдэд эргэн төлөгдөх нөхцлөөр олгох, дэмжлэг үзүүлэхээр Мал хамгаалах сангийн эргэн төвлөрсөн 450 сая төгрөгийг тусгуулан ажиллаж байсан боловч төсвийн тодотголоор хасагдсан. Цаашид эдгээр аж ахуйн нэгжүүдийг мэдээлэл, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллах бөгөөд “Гацуурт” ХХК-иас авах махны чиглэлийн “Лимүзэн” үүлдрийн үхрийг дээрхи аж ахуйн нэгжүүдэд эргэн төлөгдөх нөхцөлөөр олгож үхэр сүргийн ашиг шимийг нэмэгдүүлэх арга хэмжээ авахаар төлөвлөж байна.</p>	
Зорилт 4. Хүнс, хөнгөн, жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын хөгжлийг эрчимжүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ							
4.1	МУТХҮБ-ын 2.1.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.20 дахь заалт	Хүнсний үйлдвэрлэлийн салбарын эрх зүйн орчныг сайжруулж, хүнсний хангамж, аюулгүй байдлыг дээшлүүлэх	Шинээр болон шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо	3	0.34 Улсын төсөв	1.Баяжуулсан хүнсний тухай хуулийн төслийг УИХ-ын нэр бүхий гишүүд санаачлан боловсруулж УИХ-д 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр өргөн барьсан. Энэ ажлын хүрээнд олон улсад баримталж буй чиг хандлага болон бусад улс орны хууль, эрх зүйн баримт бичгийг судлан орчуулах, тандалт судалгаа, баримтын судалгаа хийсэн. Баяжуулсан хүнсний тухай хуулийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцэхээр шийдвэрлэсэн бөгөөд холбогдох байнгын хороонд ажлын хэсэг	40

						<p>гарсан ажиллаж байна.</p> <p>2.Сүү, сүүн бүтээгдэхүүн болон давс үйлдвэрлэгч хувийн хэвшлийн төлөөллийг хамруулан Хүнс баяжуулах тухай хуулийн төслийн талаар 2017 оны 5 дугаар сарын 23-нд хэлэлцүүлэг зохион байгуулж, санал мэдээлэл солилцсон.</p> <p>Тус яамнаас УИХ-ын НББСШУБХ, ЭМЯ, ШУТИС, Харвардын эрдэм шинжилгээ, судалгааны нэгжтэй хамтран “Төв Евроазийн шим тэжээлийн анхдугаар чуулган”-ыг 2017 оны 6 дугаар сарын 7-9-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулсан. Чуулганд болон чуулганы үеэр зохион байгуулсан салбар хэлэлцүүлгүүдийн арга хэмжээнд АНУ, ИБУИНВУ, Япон, ХБНГУ, Швейцар, БНХАУ, Казакстан, Тажикстан зэрэг орноос, мөн олон улсын байгууллага, Монгол Улсын төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөл нийт 200 гаруй хүн оролцсон. Чуулганаас “Улаанбаатарын тунхаг” баримт бичгийг гаргасан. Чуулганы арга хэмжээний хүрээнд ХХААХҮЯ-нд 2017 оны 6 дугаар сарын 8-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулж хүнс баяжуулахын ач холбогдлын талаар санал, мэдээлэл солилцсон.</p> <p>Зохицуулах үйлчилгээтэй хүнсний тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулахаар төлөвлөж, бусад улс орны хууль эрх зүйн орчны талаар баримтын судалгаа хийж байна. /УИХ-ын 2017 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор баталсан Хууль, тогтоомжийг 2016-2020 онд боловсронгуй болгох Үндсэн чиглэлд Зохицуулах үйлчилгээтэй хүнсний тухай хуулийн төслийг УИХ-д 2019 онд өргөн мэдүүлэхээр тусгасан.</p> <p>3.Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлага тогтоох тандалт судалгаа хийж байна. /Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар нийтийн хоолны зэрэглэл олгох эрх зүйн үндсийг бүрдүүлэх бөгөөд холбогдох хуулийн төслийг УИХ-д 2018 онд өргөн мэдүүлэх тухай заасан.</p> <p>4."Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт"-ын төслийг боловсруулсан. Техникийн зохицуулалтын төслийн хэлэлцүүлгийг яамны холбогдох газар, хэлтсүүдийн хүрээнд 5 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан саналыг тусгаад байна. Техникийн зохицуулалтыг 2017 оны 3 дугаар улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.</p>	
--	--	--	--	--	--	---	--

						<p>5.Органик хүнсний тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хуулийн хүрээнд дагалдаж гарах дараах дүрэм, журам, аргачлал, зөвлөмжийн төслийг боловсруулсан бөгөөд 2017 оны 2-4 дүгээр сард нийт 16 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан саналуудыг нэгтгээд байна. Үүнд: Органик газар тариалан эрхлэхэд баримтлах журам; Органик мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхэд баримтлах журам; Органик зөгийн аж ахуйд тавигдах шаардлага; Органик бүтээгдэхүүнийг боловсруулахад баримтлах журам; Органик хүнсийг боловсруулахад баримтлах журам; Хүнсний бүтээгдэхүүний органик орцын хувь хэмжээг тооцох аргачлал; Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журам; Оролцооны баталгаажуулалтын байгууллагад тавигдах шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журам Органик хүнсний үйлдвэрлэл болон органик хөдөө аж ахуйд хэрэглэгдэх бодисуудын жагсаалтууд.</p>	
		Хүнсний хангамж, аюулгүй байдал, хяналтын судалгаа хийх ажлын явц, хувиар	100.0			<p>1.Хүнсний аюулгүй байдлыг хангахад оюутан, судлаач, эрдэм шинжилгээний ажилтны оруулах хувь нэмрийг үнэлэх, төрийн бодлого, шийдвэрт тусган хэрэгжүүлэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх, төр, эрдэм шинжилгээний байгууллагын хамтын ажиллагааг дэмжих, хүнсний салбарын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор “Хүнсний аюулгүй байдал” эрдэм шинжилгээний бага хурлыг уламжлал болгон жил бүр зохион байгуулах удирдамжийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар батлуулсан. Удирдамжийн дагуу бага хурал зохион байгуулах ажлын хэсгийг ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны А-197 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгээс “Хүнсний аюулгүй байдал-2017” бага хурлыг хүнсний хангамж, үйлдвэрлэл, хүртээмж гэсэн хүрээнд зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Энэ бага хурлыг Дэлхийн хүнсний өдрийг тохиолдуулан жил бүрийн 10 дугаар сарын 16-нд уламжлал болгон зохион байгуулна. Тус арга хэмжээний хүрээнд хүнсний аюулгүй байдлын талаар судалгаа хийгдэж, бодлого шийдвэрт тусган хэрэгжүүлэх нөхцөл, боломж бүрдэнэ.</p> <p>2.Засгийн газрын 2017 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн 46 дугаар тогтоолын хүрээнд “Согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, тусгай зөвшөөрлийн хугацаа, нөхцөл, шаардлагын</p>	40

						хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх тухай” удирдамжийг баталсан. Удирдамжийн дагуу 3 ажлын хэсгийг томилон, улсын хэмжээнд хяналт шалгалтыг хийсэн. Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулж байгаа Улаанбаатар, Ховд, Дорнод, Өмнөговь, Увс, Баян-Өлгий, Дундговь, Хөвсгөл, Архангай, Төв, Сэлэнгэ, Булган, Дархан-Уул, Орхон, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Завхан аймгуудад ажилласан бөгөөд хяналт шалгалтын дүнг энэ оны 7 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулж, холбогдох шийдвэр гаргуулна.																																		
4.2	МУТХУБ-ын 2.1.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.54 дэх заалт	Хөнгөн үйлдвэрийн салбарыг бодлогоор дэмжиж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хөнгөн үйлдвэрийн технологийн парк байгуулах /БТГ, МХС/	Ноос, арьс ширэнд олгох урамшууллын хэмжээ, тэрбум төгрөг	38	38.0 Улсын төсөв	22,6	Үндэсний үйлдвэрт 21 аймаг, нийслэлийн сум, дүүргээс 2011-2016 онд нийт 506717 малчид, мал бүхий этгээдийн тушаасан 87143,3 тн хонь, тэмээний ноосонд 136 тэрбум төгрөг, үүнээс 2016 онд нийт 92,885 малчин, мал бүхий этгээдийн тушаасан 20,599 тн ноосонд 22,6 тэрбум төгрөгийг Монголбанкаар дамжуулан малчдын дансанд шилжүүлэв. Малчдад олгосон ноосны урамшуулал <table border="1"> <thead> <tr> <th>Он</th> <th>Малчны тоо</th> <th>Ноосны хэмжээ /тн/</th> <th>Мөнгөн дүн /тэрбум төгрөг/</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>2011</td> <td>32,977</td> <td>4 924.9</td> <td>9.8</td> </tr> <tr> <td>2012</td> <td>103,162</td> <td>14 696.6</td> <td>29.4</td> </tr> <tr> <td>2013</td> <td>117,667</td> <td>18 307.3</td> <td>36.6</td> </tr> <tr> <td>2014</td> <td>80,619</td> <td>16 643.5</td> <td>18.3</td> </tr> <tr> <td>2015</td> <td>79,407</td> <td>16 897.0</td> <td>19.3</td> </tr> <tr> <td>2016</td> <td>92,885</td> <td>20 598.9</td> <td>22.6</td> </tr> <tr> <td>ДҮН</td> <td>506,717</td> <td>92068.3</td> <td>136</td> </tr> </tbody> </table> <p>Мэдээллийн эх сурвалж: Мал хамгаалах сан 2017 оны төсөвт Засгийн газрын 2017-01-11-ний 14-р тогтоолоор ХХААХҮ-н Төсвийн ерөнхийлөн захирагчийн ноосны урамшуулалд 22,6 тэрбум төгрөг, арьс ширний урамшуулалд 10,8 тэрбум төгрөг багтагдсан. Ноосны урамшууллын 22,6 тэрбум төгрөг 100 хувь малчдад олгосон. 2016 онд нийт 64,255 малчин, мал бүхий этгээдийн тушаасан 3,1 сая арьс, ширэнд 12,7 тэрбум төгрөг олгох ХХААХҮ-ийн Сайдын тушаал гарсан бөгөөд Сангийн яаманд зарцуулалтын эрх нээгдвэл 6-р сард багтаан малчдын дансанд урамшууллын гүйлгээ хийгдэх болно.</p>	Он	Малчны тоо	Ноосны хэмжээ /тн/	Мөнгөн дүн /тэрбум төгрөг/	2011	32,977	4 924.9	9.8	2012	103,162	14 696.6	29.4	2013	117,667	18 307.3	36.6	2014	80,619	16 643.5	18.3	2015	79,407	16 897.0	19.3	2016	92,885	20 598.9	22.6	ДҮН	506,717	92068.3	136	40
Он	Малчны тоо	Ноосны хэмжээ /тн/	Мөнгөн дүн /тэрбум төгрөг/																																					
2011	32,977	4 924.9	9.8																																					
2012	103,162	14 696.6	29.4																																					
2013	117,667	18 307.3	36.6																																					
2014	80,619	16 643.5	18.3																																					
2015	79,407	16 897.0	19.3																																					
2016	92,885	20 598.9	22.6																																					
ДҮН	506,717	92068.3	136																																					
			Технологийн парк байгуулах бэлтгэл ажлын явц, хувиар	100.0	/30 хувь/		УИХ-ын 2012 оны 74 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэхээр Арьс, ширний үйлдвэрүүдийг Эмээлтийн үйлдвэрийн шинэ бүс рүү шилжүүлэх арга хэмжээг 2017-12- 31-ний дотор үе шаттайгаар зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх чиглэлээр ХХААХҮ-ийн Сайд, Нийслэлийн Засаг даргатай хамтран ажиллах	70																																

						<p>гэрээнд тусган ажиллаж байна.</p> <p>Дээрхи үйлдвэрийн бүсийг үйлдвэрлэл технологийн паркийн хэлбэрээр зохион байгуулахаар төслийн бэлтгэл ажлыг гүйцэтгээд байна. Үүнд:</p> <p>“Аж үйлдвэрлийн парк”-ийн техник эдийн засгийн үндэслэл, Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол Үерийн байгууламжийн ажлын зураг төсөл, Цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл, Технологийн усан хангамжийн ажлын зураг төсөл, Ундны усан хангамжийн ажлын зураг төсөл, Паркийн техник технологийн түвшний үнэлгээ, Паркийн цэвэрлэх байгууламжийн судалгаа зэрэг баримт бичгүүдийг боловсруулж, эрх бүхий байгууллагуудаар баталгаажуулсан. Бүтээн байгуулалтын хувьд барилга угсралтын үеийн цахилгаан хангамжийн эх үүсвэрийг байгуулаад байна. "Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн ҮТП" ОНӨТҮГ, "Налайхын барилгын материалын ҮТП" ОНӨТҮГ, "САМОМ-45 - Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл технологийн парк" зэрэг байгууллагуудаас үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар ирүүлсэн хүсэлт, материалыг судалж, Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж яамдын саналыг тусган, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр 2017 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 01/1777 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлэв.</p>		
4.3	МУТХУБ-ын 2.1.1, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 2.15 дахь заалт	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг санхүү, зээлийн бодлогоор дэмжих ЖДҮХБХЗГ, ЖДҮХС	Санхүүжүүлэх төслийн тоо	400	20.0 Улсын төсөв	-	<p>Засгийн газрын 2016-2020 үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан үйлдвэржилтийг дэмжих зорилт, арга хэмжээний хүрээнд экспортыг нэмэгдүүлж, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин, гарааны бизнес эхлүүлэх болон ажлын байр бий болгож, нэмэгдүүлэх зорилгоор ЖДҮХ Сан 2016 оны 11 дүгээр сарын 11 - 23-ны өдрүүдэд иргэд, аж ахуйн нэгжүүдийн төслийг хүлээн авлаа. Энэ хугацаанд ЖДҮХСанд нийт 494,2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл хүссэн 704 иргэн, аж ахуйн нэгжийн төсөл ирснээс зээл, төслийн ажлын хэсэг төсөл тус бүрийн зээлийн зарцуулалт, ажлын байр, дэвшилтэт технологи, суурь бааз, борлуулалтын орлого зарлага, зах зээлийн судалгаа хийсэн байдал, бүтээгдэхүүний зах зээлийн судалгааны үнэлгээ, борлуулалт зардлын төлөвлөлт, бэлэн мөнгөний урсгалын төлөвлөлт зэрэг үндсэн гол үзүүлэлтүүдээр үнэлгээ хийсэн. Төсөл сонгон шалгаруулах хорооны хурлаар нийт 611 төсөл хэлэлцэгдэж, 196 төслийг дэмжиж санхүүжилтийг хийж эхлээд байна.</p>	40

						Жижиг, дунд үйлдвэрийн зориулалттай хөнгөлөлттэй зээлийг шалгаруулах, олгох, хяналтгавих журмын төслийг боловсруулан иргэд ААН-ээр хэлэлцүүлэн саналыг тусган төслийг батлуулахаар ажиллаж байна.		
4.4	МУТХҮБ-ын 2.1.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.48 дахьзаалт	“Үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх 21:100” хөтөлбөр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг эхлүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	10.0	0.5 Улсын Төсөв 1.3 Бусад эх үүсвэр	0.012	<p>1. ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2016 оны А/ 157 дугаар тушаалаар “Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр” –ийн төсөл боловсруулах Ажлын хэсгийг байгуулж, 2,19 сая төгрөг зарцуулахаар төсөвлөснөөс 622,8 мянган төгрөг зарцуулсан. Энэхүү ажлын хэсгийн боловсруулсан хөтөлбөрийн төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулсан.</p> <p>Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааны 60. ХХҮШ.7 тэмдэглэлээр Засгийн газрын гишүүдээс гарсан санал болон орон нутаг, яамдын саналыг тусган Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-д заасан нөхцөл шаардлагын дагуу “Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр” –ийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх үүрэг өгсөн.</p> <p>ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2017 оны А/57 дугаар тушаалаар “Үйлдвэржилт 21:100” хөтөлбөр боловсруулах Ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хэсгийн зардал 8,1 сая төгрөг, хөтөлбөрийн төсөл боловсруулах салбаруудын хэлэлцүүлгийн зардалд 10,6 сая төгрөгийг тус тус баталсан.</p> <p>“Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр” боловсруулахаар шинэчлэн байгуулагдсан ажлын хэсэг дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд 12 сая төгрөгийн зардал гарсан.</p> <p>Хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн байдалд үндэслэн макро, микро түвшингийн орчны шинжилгээ хийсэн.</p> <p>Хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийн салбарын үйлдвэрлэгч, мэргэжлийн холбоод, эрдэмтэд, суудлаачид, түүхий эд бэлтгэгч, малчдын төлөөллийг хамруулан 12 удаа хэлэлцүүлэг зохион байгуулж, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга замын талаар санал авч, хөтөлбөрийн зорилго, зорилтыг томьёолсон.</p> <p>Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах журмын талаар ЗГХЭГ-ын референт, сангийн яамны мэргэжилтнүүдээс зөвлөгөө авч, яамны мэргэжилтнүүдийг сургалтад хамруулсан.</p> <p>Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-д заасан нөхцөл шаардлагын дагуу хөтөлбөрийн төслийн</p>	40

						<p>хавсралтуудыг боловсруулахаар ажлын хэсгийг дэд ажлын хэсэгт хувааж үүрэгжүүлэн ажилласан.</p> <p>“Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр” –ийн төслийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа болон байгуулах үйлдвэрүүдийн эдийн засаг, хөрөнгө оруулалтын тооцоо боловсруулахад зөвлөх үйлчилгээгээр гүйцэтгүүлсэн.</p> <p>“Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр” –ийн төслийг Сайд, сайдын зөвдөх, холбогдох газрын дарга нарт 2017 оны 4-р сарын 12-ны өдөр танилцуулсан.</p> <p>“Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр” –ийн төслийг боловсруулж дуусган 2017 оны 5-р сарын 12-ны өдрийн 01/1470 албан бичгээр яамдуудаас санал авахаар хүргүүлсэн. Яамдын санал 2017 оны 6-р сарын 15-ны байдлаар бүрэн авч дуусав.</p> <p>Яамдын ирүүлсэн саналын дагуу хөтөлбөрийн төслийг боловсруулж, Сангийн яамнаас зөвшөөрөл авах, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэв.</p> <p>“Үйлдвэржилт-21:100” хөтөлбөрийн хүрээнд үйлдвэржилтийн газрын зураг гаргав. Аймгуудын үйлдвэржилтийн өнөөгийн байдлын зургийг аймаг тус бүрээр гаргаж, улсын хэмжээнд 16 салбарын нийт 30 гаруй сэдэвчилсэн зургуудын эхийг бэлтгэж, хэвлэмэл болон цахим хэлбэрээр хийж гүйцэтгэсэн.</p> <p>/12,0 сая төгрөгийн ажил гүйцэтгэсэн байна. /</p>	
4.5	МУТХҮБ-ын 2.1.1, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 5.6.8 дахь дэдзаалт	Дотоодын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор гадаад орнуудад “Монголд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг зохион байгуулах	Зохион байгуулах үзэсгэлэн худалдааны тоо	2-оос доошгүй	0.2 Улсын төсөв	<p>- 2017 оны 4 дүгээр улиралд БНХАУ-ын ӨМӨЗО-ын Хөх хотод “Монгол Хятадын экспо” хоёр дахь удаагийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулахаар ХХААХҮЯамны ТНБД-аар ахлуулсан ХХААХҮ-ийн Сайдын 2016-12-22-ны өдрийн А-78 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2017-03-23-ны өдөр Хятадын талын төлөөлөгчдийг хүлээн авч ажил хэргийн уулзалтыг зохион байгууллаа.</p> <p>Мөн ӨМӨЗО-ын талын ажлын хэсгээс ирүүлсэн хөтөлбөрийн төслийг бүх яамд болон агентлагуудаас санал авч нэгтгэв.</p> <p>Мөн цаашид экспоны арга хэмжээг өндөр түвшинд зохион байгуулах, эрчимжүүлэх зорилгоор 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн Засгийн Газрын хуралдаанаар хэлэлцүүлж ХХААХҮ-ийн Сайд П.Сэргэлэнгээр ахлуулсан байнгын ажлын хэсгийг байгуулах, "Монгол-Хятадын Экспо" арга хэмжээг зохион байгуулах ажлын төлөвлөгөө, шаардагдах зардлын төсвийг тухай бүр батлуулан бэлтгэл ажлын явц, үр дүнгийн талаар Засгийн газарт танилцуулж ажиллахыг ажлын хэсэгт даалгасан Засгийн газрын 150-р тогтоол гаргав.</p> <p>- Монголд үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг олон улсын болон хөрш орнуудын зах зээлд гаргах зорилгоор үзэсгэлэн</p>	40

							худалдаа, экспо зохион байгуулах хүрээнд Японы Жайка байгууллагын сайн дурын ажилтан Юко Хондатай хамтран бараа бүтээгдэхүүний сав баглаа боодол, загвар дизайныг сайжруулах талаар цайны бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 35 иргэн ААН, инкубаторуудын холбооны бойжигч 20 иргэнд сургалтыг зохион байгуулав.	
							Дундаж үнэлгээ	41.1